




СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



СОЁЛЫН ӨВИЙГ ХАДГАЛАХ,
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ОЛОН
УЛСЫН СУДАЛГААНЫ ТӨВ



**Гамшиг, эрсдэлийн нөхцөлд соёлын өвийг
яаралтай нүүлгэн шилжүүлэх арга зүй**



СОЁЛЫН ӨВИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВ



СОЁЛЫН ӨВИЙГ ХАДГАЛАХ,
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ ОЛОН
УЛСЫН СУДАЛГААНЫ ТӨВ

**Гамшиг, эрсдэлийн нөхцөлд соёлын өвийг
яаралтай нүүлгэн шилжүүлэх арга зүй**

ЮНЕСКО (Франц улс, Парис хот, Фонтеной 75352), Соёлын Өвийг Хадгалах, Сэргээн Засварлах Олон Улсын Судалгааны Төв (Итали улс, Ром хот, Сан Мишель 13), Соёлын Өвийн Үндэсний Төв (Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 21-р хороо, Буянт-Ухаа 2) хамтран 2023 онд хэвлэв.
© UNESCO / ICCROM / NCCH 2023

ISBN 978-92-3-000206-0



Энэ хэвлэлийг Attribution ShareAlike 3.0 IGO (CCBY-SA 3.0 IGO) лицензийн дагуу ашиглах боломжтой (<http://creativecommons.org/licenses/by-sa/3.0/igo/>). Нээлттэй нийтлэлийн агуулгыг ашигласнаар хэрэглэгчид ЮНЕСКО-ийн Нээлттэй хандалтын сан (<http://www.unesco.org/open-access/terms-useccby-saen>) болон ICCROM Нээлттэй хандалтын сангийн ашиглалтын нөхцөлийг дагаж мөрдөнө.

Эх сурвалж: Endangered Heritage: Emergency Evacuation of Heritage Collections

Анхны хэвлэлийг ЮНЕСКО болон СӨХСЗОУСТ хамтран 2016 онд хэвлэв.

Энэхүү гарын авлагад ашигласан тэмдэглэгээ, мэдээлэл нь аливаа улс орон, нутаг дэвсгэр, хот, бүс нутгийн эрх зүйн байдал, эсвэл түүний эрх баригчдын эрх зүйн байдлын талаар, эсвэл хилийн заагийг тогтоох талаар ЮНЕСКО-оос ямар нэгэн үзэл бодлоо илэрхийлээгүй болно.

Энэхүү нийтлэлд илэрхийлсэн санаа, үзэл бодол нь зохиогчдынх болно. Эдгээр нь ЮНЕСКО /UNESCO/ болон Соёлын Өвийг Хадгалах, Сэргээн Засварлах Олон Улсын Судалгааны Төв /ICCROM/-ийнх байх албагүй бөгөөд байгууллагад үүрэг хүлээдэггүй.

Тус гарын авлагыг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл урлагийн газрын санхүүжилтээр хэвлэв.

Хамтран оролцсон

| | |
|---|--|
| Эмхэтгэсэн | Aparna Tandon, ICCROM, NCCH (СӨҮТ) |
| Зураг | Abdel Hamid Salah (Өөрөөр заагаагүй бол), Соёлын Өвийн Үндэсний Төв |
| Мэдээллийн дизайн болон зураглал | Visuality - www.visuality.be |
| Хэвлэсэн | ICCROM-ATHAR |
| Судалгаа | Eugénie Crété & Alessia Strozzi, for ICCROM Amira Sadik, HebatAllah AbdelHamid, Dalia Hassan & Sara Nor, EHRF |
| Зохицуулалт | Catherine Antomarchi, Aparna Tandon & Isabelle Verger, ICCROM Nao Hayashi, UNESCO |
| СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ | |
| Редактор: | Г.Энхбат |
| Эрхэлсэн: | А.Саруул, Г.Анхсанаа |
| Орчуулсан: | О.Цэвэлмаа |

Удиртгал

1945 онд Дэлхийн II дайны хохирол, сүйрлийн дараа ЮНЕСКО нь хүн төрөлхтөний оюун ухаанд эрхэм чанар эрх тэгш байдал, харилцан хүндэтгэлийг бат бөх ухамсарлуулсны үндсэн дээр энх тайвныг бий болгож чадна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан байгуулагдсан билээ. Музейн алсын хараа ч үүн дээр суурилдаг. Музей нь эрдэм мэдлэг, эд өлгийн дурсгалыг хадгалагч сүм хийд байхаа больж, оюуны солилцоо, бүтээлч сэтгэлгээг идэвхжүүлснээр боловсрол, нийгмийн эв нэгдэл, тогтвортой хөгжилд чухал үүрэг гүйцэтгэж, өвөрмөц байдлын бэлгэдэл болж байна. Музей нь нийгэмд тустай олон төрлийн үүргийг гүйцэтгэсээр байгааг Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрсөөр ирсэн.

Сүүлийн арваад жилийн хугацаанд музей болон соёлын өвийн байгууллагууд нь хэт даврагсдын бай болсоор ирлээ. Бидний дэмжиж ажиллах ёстой зүйл нь музейн гол үүрэг болох өнгөрснийг гэрчлэх, хүний бүтээлч байдлыг хадгалан хамгаалах, үүгээрээ соёл хоорондын харилцан ойлголцол, нэгдмэл ойлголтыг бий болгоход оршино.

Түүнчлэн байгалийн гамшиг, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас музей болон түүний албан хаагчид хүнд хэцүү сорилтыг даван туулдаг. ЮНЕСКО болон Соёлын өвийн хадгалалт, сэргээн засварлалт, судалгааны Олон улсын төв нь төрөл бүрийн эрсдэл, онцгой нөхцөл байдалд хариу арга хэмжээ авах музейн чадавхыг бэхжүүлэхэд анхааран ажилладаг. Мөн соёлын өвийн салбарт шийдвэр гаргах түвшинд болон үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоог хангах нь ЮНЕСКО болоод гишүүн орнуудын хувьд тулгамдсан асуудлуудын нэг гэдгийг онцлох нь зүйтэй. Энэ нь тогтвортой хөгжилд хөтлөх зайлшгүй шаардлага мөн. Иймд онцгой байдлын үед олон талт нөхцөл байдлын арга барилаар дамжуулан эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь үндэсний хэмжээнд бодлого боловсруулахад жендэрийн мэдрэмжтэй үйл ажиллагааны зохих үр дүнд хүргэх юм. Эдгээр зөвлөмжүүд нь холбогдох бүх талуудын ашиг сонирхолд нийцнэ гэдэгт чин сэтгэлээсээ найдаж байна.

Гарын авлагын ач холбогдол, хэрэгцээ

Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын өвийг авран хамгаалах нь хүч сорьсон, хэцүү бөгөөд амь насанд эрсдэлтэй үйл ажиллагаа. Гэсэн хэдий ч зэвсэгт мөргөлдөөн, дайны бүсэд оршиж буй хамт олон үймээн самуун, тодорхойгүй байдлын дунд өвийг хамгаалах арга хэмжээг тасралтгүй авч, зоригтойгоор хичээн ажиллаж ирсэн. 2013 онд Малигийн хойд хэсэгт дэгдсэн мөргөлдөөний үеэр хувийн эзэмшилд байсан гар бичмэлийн цуглуулгыг Тимбуктугаас амжилттай нүүлгэн шилжүүлсэн нь соёлын өвийн хамт олноор удирдуулсан аврах ажиллагааны тод жишээ юм.

Энэхүү гарын авлага нь СӨХСЗСОУТ /ICCR0M/-ийн чадавхыг бэхжүүлэх санаачилгын хүрээнд онцгой шаардлага бүхий нөхцөлд соёлын өвд үзүүлэх анхны тусламжийн талаар газар дээрх ижил төстэй туршлагын үр дүнд суурилсан, эрс тэс нөхцөлд соёлын өвийн цуглуулгыг нүүлгэн шилжүүлэх талаарх алхам бүрийн зааварчилгааг багтаасан, мөн онцгой нөхцөл байдалд соёлын дурсгалт зүйлсийг сүйтгэх, тонож дээрэмдэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эрхлэн явуулах хамт олонд чиглэгдсэн юм. Гарын авлагыг яаралтай тусламжийн бэлэн байдлыг сайжруулах зорилгоор сургалтад ашиглаж болно.

Онцгой байдлын нөхцөлүүд ижил төстэй биш гэдгийг харгалзан энэхүү гарын авлагад наад захын алхамуудыг тайлбарласан ба хэрэгцээнд нийцүүлэн өөрчилж болно. Авран хамгаалах ажлын явцыг газар дээр нь үзүүлэх дадлага ажлыг хийж гүйцэтгэсэн Каир хотод төвтэй Египетийн өвийг аврах сан (EHRF)-д редакцын зүгээс талархал илэрхийлж байна. Египетийн өвийг аврах сан нь онцгой нөхцөлд соёлын өвд анхны тусламж үзүүлэхээр бэлтгэгдсэн 97 хүний бүрэлдэхүүнтэй баг юм. Тус багийнхан 2014 онд бөмбөг дэлбэрсний улмаас гэмтсэн Каир хотын Исламын урлагийн музейн цуглуулгыг авран хамгаалах ажиллагааг хийж гүйцэтгэсэн.

Түүнчлэн гарын авлагад ашиглагдаж буй гэрэл зураг, үзүүлэн зэргийг Соёлын Өвийн Үндэсний төвийн Авран хамгаалах, эрсдэлийн судалгааны газраас бэлтгэн оруулав. Тус гарын авлага дах мэдээллийг нь оновчтой байлгахын тулд хүчин чармайлтаа гаргаж ажиллаа. Гарын авлагыг улам бүр сайжруулах санал хүсэлт, шүүмжийг хүлээн авахад таатай байх болно.

ХЭЗЭЭ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ВЭ?

Музей эсвэл археологийн дурсгалт газраас аюулд өртсөн эд өлгийн зүйлс, цуглуулгыг нүүлгэн шилжүүлэх шийдвэр нь тун чухал шийдвэр юм. Сайтар төлөвлөж, тооцоолоогүй яаран гүйцэтгэсэн алхам нь соёлын үнэт зүйлсийг шинэ, урьдчилан таамаглаагүй аюулд хүргэж болзошгүй. Иймд дараах бүх нөхцөлийг хангасан тохиолдолд л энэ шийдвэрийг гаргах нь зүйтэй.

- Танай байгууллагад үүссэн аюул, эрсдэл бодит эсэх;
- Тухайн үед хэрэгжүүлж буй арга хэмжээ нь цуглуулгад хохирол учрахаас урьдчилан сэргийлэх боломжгүй;
- Цуглуулга хадгалах аюулгүй газар, сан хөмрөгтэй байх;
- Эд зүйлсийг нүүлгэх шилжүүлэх албан ёсны зөвшөөрөлтэй байх;
- Цуглуулгыг нүүлгэн шилжүүлэхэд хангалттай хүн хүч, нөөцтэй байх;
- Авран хамгаалах ажиллагаанд оролцож буй хүмүүсийн аюулгүй байдлыг хангасан байх.

ХЭРХЭН НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ВЭ?

Дараагийн бүлгүүдэд нүүлгэн шилжүүлэх ажлын явцыг тайлбарлах болно.

1. Үнэлгээ хийх
2. Бэлтгэх
3. Баримтжуулалт, сав баглаа, тээвэрлэлт
4. Нүүлгэн шилжүүлэх, хадгалах



Ажиллах үйл явц

ҮНЭЛЭХ



БЭЛТГЭХ



Та энд байна →

→ ҮНЭЛЭХ

→ БЭЛТГЭХ

→ БАРИМТЖУУЛАЛТ,
САВ БАГЛАА,
ТЭЭВЭРЛЭЛТ

→ НҮҮЛГЭН
ШИЛЖҮҮЛЭХ,
ХАДГАЛАХ


БАРИМТЖУУЛАЛТ, САВ
БАГЛАА, ТЭЭВЭРЛЭЛТ



НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ,
ХАДГАЛАХ

Үнэлэх


- 1 ЭРСДЭЛИЙГ ҮНЭЛЭХ, ТООЦОХ
- 2 ЭРСДЭЛИЙГ ХААХ
- 3 ҮЗМЭРИЙГ ЭРЭМБЭЛЭХ



1



2



1 Эрсдэлийг үнэлэх




Эрсдэл бодитой эсэхийг үнэл

Тодорхой аюул эрсдэлийн магадлалд дүн шинжилгээ хийх, тухайлбал, танай байгууллагад нөлөөлж буй үер эсвэл үймээн самуун. Байгууллагын байршил нь ихэвчлэн тодорхой нэгэн эрсдэлд өртөмтгий болгодог. Тухайлбал, музейн ойр орчимд хүчтэй үймээн дэгдэх нь түүний аюулгүй байдалд эрсдэл учруулж буй юм. Ийм тохиолдолд холбогдох ажилтнууд эвдэн сүйтгэх/дээрэм тонуул хийх эрсдэлийг бодитой гэж үзэж, зохих арга хэмжээ авах ёстой.

Үүний нэгэн адил археологийн дурсгалт газар нь үер усны ойролцоо байрладаг бол эрсдэлтэй хэмээн үзнэ.

2 Эрсдэлийг хаах



Эрсдэлийг хаах болон урьдчилан сэргийлэх

Хэрэв тухайн эрсдэл нь бодитой хэмээн үзвэл уг эрсдэлийг танай байршил руу нэвтрэхийг нь зогсоох үр дүнтэй хариу арга хэмжээ бий эсэхийг шалгах. Эдгээр арга хэмжээ нь тодорхой эрсдэл рүү чиглэсэн байх шаардлагатай.

Тухайлбал, музейг зэвсэгт дээрэмчдээс хамгаалах хувилбарыг авч үзье. Энэ тохиолдолд аюул заналхийллийн эсрэг дараах хариу арга хэмжээг авч болно. Үүнд:

- Музейн барилгыг хамгаалах нэмэлт хамгаалалтын ажилтнуудыг байршуулах,
- Музейн барилгын эргэн тойронд бетонон хаалт тавих эсвэл хүчээр орохыг хориглохын тулд хаалга, цонхыг бэхлэх.

Хэрэв ямар нэг шалтгааны улмаас аюул заналхийлж буй музей арга хэмжээ авах боломжгүй тохиолдолд холбогдох байгууллагууд ажилтнууд болон цуглуулгуудыг хоёуланг нь нүүлгэн шилжүүлэх ажилд бэлэн байлгах ёстой.

3 Үзмэрийг эрэмбэлэх

Нэн түрүүнд нүүлгэн шилжүүлэх шаардлагатай үзмэрүүдийн жагсаалтыг гаргах



Тэргүүлэх зүйлсийн жагсаалтыг бэлтгэ.


Хариуцсан ажилтан эсвэл үзмэр харгалзагчтай зөвлөлдөж, нүүлгэн шилжүүлэх шаардлагатай хамгийн үнэ цэнтэй үзмэрүүдийн бүртгэл, бичиг баримтыг шалгана уу. Эдгээр үзмэрүүдийг хялбар танихын тулд хажууд нь жижиг цаас байрлуулж тэмдэглэнэ.

Хэрвээ тус үзмэрийн тодорхой мэдээлэл байхгүй бол, аюулд өртөх магадлалтай эн тэргүүний зүйлсийнхээ жагсаалтыг гаргаарай.

Үүнийг хийх энгийн арга бол танай байгууллагад аюул заналхийлж болзошгүй нөхцөлийг хайж, дараа нь тэдгээр аюул заналхийлэлд хялбар өртөх үзмэрүүдийг урьдчилан жагсаах явдал юм. Дээр тайлбарласны дагуу үзмэрүүд болон тэдгээрийн байршлыг тодорхойлохын тулд жижиг цаас ашиглана уу.



Жишээ нь: Хэрэв зэвсэглэсэн дээрэмчид музейн урд хэсгээр нэвтэрч чадвал, ойр орчимд нь байрлах үзмэрүүд амархан гэмтэж, дээрэмд өртөнө.





Анхааруулга: Зарим нөхцөлд аюулд өртөх замыг тодорхойлоход хэцүү байдаг. Энгийн жишээ нь мөргөлдөөний бүсэд байрлах аль ч талаас нь галлаж болох археологийн дурсгалт газар юм.

Үзмэрүүдийн үнэ цэн болон аюулд өртөх зам нь тодорхойгүй үед хэрхэн эрэмбэлэх вэ?



Гамшигт өртсөн үзмэрүүдийн ач холбогдол, аюулын боломжит зам тодорхойгүй тохиолдолд дараах шалгуурыг ашиглан тэргүүлэх ач холбогдол бүхий зүйлийн жагсаалтыг гаргаж болно.

Аюулд өртсөн үзмэрүүд эсвэл боломжит аюулд өртөх зам нь тодорхойгүй чухал тохиолдолд нэн тэргүүний ач холбогдол бүхий зүйлсийг жагсаахад бэлтгэхдээ дагаж мөрдөх стандартууд:

А) Үзмэрийн материал

Органик материалууд буюу цаас, мод, даавуу, зөөлөн эдлэл болоод яс нь гал үс, биологийн болон химийн бохирдуулагч бодисуудад өртөмтгий байдаг. Физик хүчин зүйлүүд нь шил, керамик, шавар зэрэг органик бус материалын бүтцийг гэмтээж болно. Тиймээс органик материалууд болон шил гэх мэт эмзэг органик бус материалаар хийсэн үзмэрүүдийг эхлээд хамгаалах хэрэгтэй.

Б) Үзмэрийн хэмжээ болон жин


Овор ихтэй эсвэл хүнд жинтэй үзмэрийг нүүлгэн шилжүүлэх хангалттай хугацаа, нөөц байхгүй байж болно.

Тухайлбал: Хүнд жинтэй чимэглэл, ханын хэмжээтэй хүрээ бүхий тосон зургууд. Эдгээр үзмэрүүдийг газар дээр нь хамгаалсан байх ёстой.




БЭЛТГЭХ

- 1 АЮУЛГҮЙ БАЙРШИЛ, ЧИГЛЭЛ
- 2 ЗӨВШӨӨРӨЛ
- 3 БАГ БҮРДҮҮЛЭХ
- 4 ТУСГАЙ ДУГААР БОЛОН БАЙРШЛЫН ДУГААР ӨГӨХ
- 5 ЯАРАЛТАЙ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ЭД ЗҮЙЛСИЙГ БЭЛТГЭХ
- 6 ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ БҮРДҮҮЛЭХ
- 7 АЖЛЫН ТАЛБАРЫГ ТОДОРХОЙЛОХ
- 8 АЮУЛГҮЙ ТЭЭВЭРЛЭЛТ






8




5



4



7



1 АЮУЛГҮЙ БАЙРШИЛ, ЧИГЛЭЛ



Аюулгүй байршил, аюулгүй замыг тодорхойлох

Та нүүлгэн шилжүүлэх шаардлагатай үзмэрүүдийн дугаар, төрлийг тодорхойлсны дараа тэдгээрийг түр хадгалах аюулгүй газар ол. Ийм орон зайг сонгохдоо дараах зүйлийг анхаарч үзээрэй:

1. Шилжүүлэх хэмжээний объектуудыг багтаах хангалттай орон зайтай байх,
2. Ариутгасан, хортон шавьж, хөгц мөөгөнцөргүй байх,
3. Агаарын солилцоо сайтай бөгөөд чийгшил нь таарсан байх,
4. Хулгай, эвдэн сүйтгэхээс хамгаалагдсан байх,
5. Үзмэрүүдийг аюулгүй тээвэрлэх боломж бүхий чиглэлийн дагуу нэвтрэх боломжтой байх бөгөөд шаардлагатай бол тодорхойгүй хугацаагаар дотор нь үзмэрүүдийг хадгалах боломжтой байх.

⚠ Анхааруулга: Туршлагаас харахад үзмэрүүдийг нэг удаа нүүлгэсэн бол хэдэн жилийн турш түр хадгалалтад үлддэг. Хадгалах газрыг сонгохдоо үүнийг санаарай.

2 АЮУЛГҮЙ БАЙРШИЛ, ЧИГЛЭЛ

Аюулгүй байршлыг тогтоосны дараа үзмэрүүдийг нүүлгэн шилжүүлэх, түр нүүлгэн шилжүүлэх талаар холбогдох байгууллагаас албан ёсны зөвшөөрөл авна уу.



3 БАГ БҮРДҮҮЛЭХ



Үйл ажиллагаа явуулах багийг бүрдүүлэх

Үүнд, эрсдэлд орсон цуглуулгыг шууд хариуцдаг бүх албан тушаалтнууд хамрагдах ёстой. Баг нь удирдагчтай байх ба үйл ажиллагааны цар хүрээ, зорилгыг тайлбарлахаас гадна багийн гишүүдэд тодорхой үүрэг даалгавар өгнө. Тухайн үүрэг даалгаврууд нь:

- Баримтжуулах,
- Хянах, боож баглах,
- Тээвэрлэлт,
- Түр хадгалах зохион байгуулалт



Анхааруулга: Багийн гишүүдийн хоорондын уялдаа холбоо, зохицуулалт нь үйл ажиллагааг амжилттай явуулахад маш чухал үүрэг гүйцэтгэдэг. Тиймээс үйл ажиллагааны аюулгүй байдал, багийн гишүүдийн хоорондын харилцааны үр дүнтэй, эрсдэлгүй хэрэгсэлийг олж тодорхойлох.


Багийн гишүүдийн хоорондын уялдаа холбоог хэрхэн сайжруулах вэ?



1. Багийг жижиг бүтцэд хувааж, нэгж бүрт тодорхой үүрэг даалгавар өг.
2. Нэгж бүрийг хэн нэгэн хариуцаж, төвлөрсөн цэгийн үүргийг гүйцэтгэнэ.
3. Холбогдох цэгүүдээс тус тусын нэгжийнхээ хийсэн ажлын талаар тогтмол мэдээлэл өгөхийг хүсэх.
4. Зохицуулалтаа сайжруулахын тулд баримт бичгийн нэгдсэн тогтолцоог бий болгох.



4 ТУСГАЙ ДУГААР БОЛОН БАЙРШЛЫН КОД ӨГӨХ



Тусгай дугаар өгч, үзмэр бүрийн байршлыг тодорхойлно.

- Үзмэрүүдийг хөдөлгөхөөс өмнө түүнд тусгай таних дугаар өгснөөр үйл ажиллагааны явцад түүний хөдөлгөөнийг хянах боломжтой болно. Нүүлгэн шилжүүлэх зорилгоор боловсруулсан дугаарлалтын систем нь энгийн, жигд, оролцогч бүх хүмүүст ойлгомжтой байх ёстой. Энэ нь зөвхөн өсөх дарааллын тоо эсвэл үсэг, тооны хослол байж болно, Жишээлбэл С32, энд С нь байгууллагын нэрийг илэрхийлнэ.

⚠ Анхааруулга: Ихэнх тохиолдолд үзмэрүүд нь эзэмшигч байгууллагаас өмнө нь өгсөн дугаартайгаа байх магадлалтай. Зарим тохиолдолд нэг ба түүнээс ч олон дугаартай байж болзошгүй. Өмнөх бүх дугаарыг яаралтай нүүлгэн шилжүүлэх бүртгэлд бүртгэх ёстой (22-р хуудсыг үзнэ үү).

- Байршлын кодыг зааж өгнө. Байршлын код нь ихэвчлэн үсэг, тооноос бүрдэх бөгөөд тухайн орон зайд байгаа үзмэрүүдийг олоход ашиглагддаг. Зарчмын хувьд өмнөх баримт бичигт байршлын кодын системийг ашигласан байх ёстой. Хэрэв тийм биш бол ойлгоход хялбар энгийн байршлын кодын системийг үүсгэ.

Зөвлөмж: Хэрхэн үзмэрүүдэд байршлын код өгөх вэ?



Байршлын код нь:


- Байгууллагын орчны код (үсэгнүүд),
- Давхарын дугаар (үзмэрүүд өөр өөр давхарт байрлах тохиолдолд л хамаарна),
- Өрөөний дугаар,
- Кабинет болон тавиурын дугаар.

Жишээ нь: Craft Gallery-ын эзэмшдэг 128 дугаартай үзмэрүүдийн байршлын код нь доод давхарт А кабинет, 1-р өрөөнд байрлана: CG.01.A.128

- Үзмэрүүдэд өгөгдсөн тусгай дугаар, байршлын кодыг агуулсан шошго хавсаргана.

Анхааруулга: Үзмэр дээр шошгыг хавсаргахдаа түүзан наалт болон үдээс ашиглахаас зайлсхийх.


- Өрөө болон нүүлгэн шилжүүлэх үзмэрүүдийг агуулсан шүүгээ, тавиурын зургийг авна. Үзмэрүүдийн шошго гэрэл зурган дээр харагдаж байгаа эсэхийг шалгаарай. Өөрөөр хэлбэл, өрөөний харах өнцгийг илтгэсэн багана, дэвсгэр зураг /давхар болгоноор нь гаргасан, ханын зузаан, хаалга цонхны байрлалыг харуулсан/ хийгээд хаана, юу байгааг илтгэсэн байршлын код бичээрэй. Хэрэв үзмэрүүдийг ханан дээр дэглэсэн бол хананы загвар зургийг зурж, үзмэрийн байршлын кодыг бичнэ үү.



5 ЯАРАЛТАЙ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НЭГДСЭН БҮРТГЭЛ БҮРДҮҮЛЭХ

Нүүлгэн шилжүүлэх зорилгоор бүртгэл бүрдүүлэх.

Хэрэв өмнөх баримт бичиг байгаа бол энэ ажлыг гүйцэтгэхэд тусална. Яаралтай нүүлгэн шилжүүлэх бүртгэлд дараах мэдээллийн талбаруудыг багтаана.

| Нэвтрэх дугаар | Өмнөх дугаар | Өгөгдсөн таних дугаар | Үзмэрийн төрөл | Материал | Хэмжээс- урт, өргөн, өндөр |
|--|--------------|---|--|----------|--|
|  <p>Өсөх тоон дарааллаар, 1-ээс хамгийн сүүлийн үзмэр хүртэл нүүлгэн шилжүүлсэн үзмэрүүдийн тоог заана.</p> | | Энэ талбар нь нүүлгэн шилжүүлэх зорилгоор тухайн үзмэрт олгосон тусгай таних дугаарыг бүртгэх явдал юм. | Үзмэрийг товч тодорхойлохын тулд үүнийг ашиглана уу. Жишээ нь: зурагтай гар бичмэл, баримал, сав ваар зэрэг. | | Үзмэрүүд ямар материалаар хийгдсэн байдлаар. Жишээ нь: шил, керамик, металл, даавуу, зөөлөн эдлэл гэх мэт. |



Гэрэл зургийг СӨҮТ

| Жин | Байршлын анхдагч код | Гэрэл зураг эсвэл дэвсгэр зургийн дугаар | Шинэ байршил | Гэрэл зураг эсвэл дэвсгэр зургийн тайлбар дугаар |
|-----|----------------------|--|--------------|--|
| | | | | |

4 дүгээр алхамд тайлбарласны дагуу үзмэрийн анхны байршлын кодыг жагсаана уу.

Нүүлгэн шилжүүлэлт дуусч, үзмэрүүдийг шинэ аюулгүй байршилд шилжүүлсний дараа энэ талбарыг бөглөнө.

Бүх зураг болон дэвсгэр зураг тайлбар дугаартай байх ёстой.

Үзмэрийн жинг энд бөглөнө үү. Хэрэв жинлэх багажгүй бол жинг харуулахын тулд + гэх мэт тэмдэгтүүдийг ашиглана уу. Жишээ нь: үзмэрийг хүн хялбархан барьж, хөдөлгөж чадвал +, үүнтэй адил хоёр хүн өргөх шаардлагатай, өргөх тээвэрлэх тусгай төхөөрөмж шаардлагатай бол ++ ба +++ ашиглана уу.



6 ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БҮРДҮҮЛЭХ

Үзмэрүүдийг баримтжуулах, зөөвөрлөх, савлах, тээвэрлэх, хадгалахад шаардлагатай хэрэглэгдэхүүнийг бүрдүүлнэ. Нүүлгэн шилжүүлэх багийнхан маск, бээлий, хамгаалалтын малгай зэрэг аюулгүй байдлын тохиромжтой хэрэгсэл ашиглах боломжтой эсэхийг шалгаарай. Аюулгүй байдлын хэрэгслийг цуглуулахдаа аюулын шинж чанар, харьцах үзмэрийн төрлийг санаарай.




Соёлын эд зүйлсийг баримтжуулах, зөөвөрлөх, савлах, тээвэрлэх, хадгалахад ашиглаж болох материалын жагсаалтыг хавсралтаас (хуудас 51) үзнэ үү.



7 АЖИЛЛАХ ТАЛБАРЫГ ТОДОРХОЙЛОХ

Нүүлгэн шилжүүлэлтийн талбайд үзмэрийг баримтжуулах, савлах ажлын талбар болгон ашиглаж болхоор талбай эсвэл хоосон өрөөг тодорхойлох. Энэ нь дор хаяж хоёр том ширээг багтаах хангалттай том байх ёстой. Баглаа боодлын материал болон бусад холбогдох хэрэглэгдэхүүнийг хадгалах өрөөтэй байх.



Гэрэл зургийг СӨҮТ


8 АЮУЛГҮЙ ТЭЭВЭРЛЭЛТ


Аюулд өртсөн газраас үзмэрийг шинэ байршил руу тээвэрлэх хамгийн найдвартай арга замыг тодорхойлох. Аюулгүй тээвэрлэхэд шаардагдах хугацааг ажиллах дарааллаар тооцсон эсэхийг шалгаарай.



Баримтжуулалт, сав баглаа, тээвэрлэлт

- 1 **ЗОХИОН БАЙГУУЛАХ**
- 2 **ЯАРАЛТАЙ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН БҮРТГЭЛИЙГ БӨГЛӨХ**
- 3 **АЖИЛЛАХ ТАЛБАРАА БЭЛТГЭХ**
- 4 **ҮЗМЭРЭЭ БАГЛАХ**
- 5 **ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ, ТЭЭВЭРЛЭЛТ**
- 6 **ШАЛГАХ**





1 ЗОХИОН БАЙГУУЛАХ

Бүх бэлтгэлийг хангасны дараа зохион байгуулалт хийхэд шаардлагатай хэрэглэгдэхүүнийг бүрдүүлж, үйл ажиллагааг эхлүүлэх.



2 ЯАРАЛТАЙ НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭЛТИЙН БҮРТГЭЛИЙГ БӨГЛӨХ

Үзмэрийн байршлыг тэмдэглэж, тэмдэглэсний дараа нүүлгэн шилжүүлэх үзмэрүүд (20-р хуудсыг үз), баримт бичгийг хариуцсан дэд баг нүүлгэн шилжүүлэх зорилгоор бэлтгэсэн бүртгэлийг бөглөж болно. (22-р хуудас)




Гэрэл зургийг СӨҮТ



3 АЖИЛЛАХ ТАЛБАРЫГ БЭЛТГЭХ

Нэгэн зэрэг баглах баг ажиллах талбарыг бэлтгэх хооронд баримтжуулах баг эд зүйлсийн бүртгэлийг бөглөх.



4 ҮЗМЭРИЙГ БАГЛАХ

Нүүлгэн шилжүүлэх бүх үзмэрийг бүртгэсний дараа тэдгээрийг урьдчилан бэлтгэсэн ажлын талбарт аваачиж, савлах ажлыг эхлүүлнэ. Савлаж дууссан эд зүйлсийн бүртгэлийн хуулбар үзмэрүүдийг дагалдаж байгаа эсэхийг шалгаарай.



Үзмэртэй харьцах зөвлөмж



Ямар нэг зүйлд хүрэхийн өмнө гараа цэвэрхэн, хуурай байгаа эсэхийг шалгаарай.

1. Тоостой эсвэл бохирдсон үзмэртэй ажиллахын тулд нэг удаагийн резин бээлий хэрэглээрэй.
2. Гэрэл зураг, зураг, будсан эсвэл өнгөлсөн гадаргуутай үзмэрүүдэд хурууны хээ үлдээхгүйн тулд үргэлж бээлий өмс.
3. Хэрэв үзмэрийг тоос шороотой орчинд хадгалж байгаа бол өөрийгөө хамгаалахын тулд амны хаалт зүүгээрэй.
4. Бээлий хэрэглэхдээ тэдгээр нь зөв хэмжээтэй, гарт таарч байгаа эсэхийг шалгаарай. Эс бөгөөс та үзмэрийг санамсаргүйгээр гэмтээж эсвэл унагаж болзошгүй.
5. Нэг үзмэрээс нөгөөд тоос шороо шилжүүлэхгүйн тулд бээлийг бохирдсон үед нь солих хэрэгтэй.
6. Эд зүйлтэй харьцахдаа та хувцас, гоёл чимэглэл гэх мэт зүйлсийг тайлж, эд зүйлд орооцолдохгүй байх нөхцөлийг хангахыг анхаарна уу.
7. Үзмэрүүдийг нэг газраас нөгөө рүү зөөвөрлөхөд замд нь эд хогшил саад болохгүй байхад анхаарах.
8. Хэт том эсвэл хүнд зүйлтэй харьцахын тулд тусламж хүсч, тэдгээрийг тээвэрлэх явцад хаалга онгойлгохоор хэн нэгнийг томилоорой.
9. Осол, эвдрэлээс зайлсхийхийн тулд нэг дор хэт олон зүйлийг зөөх хэрэггүй.



Гэрэл зургийг СӨҮТ




10. Үзмэрүүдийг зөөхөд сав, хайрцаг, тавиур ашиглана уу.
11. Боломжтой бол хол зайд юм зөөвөрлөхийн тулд түрдэг тэрэг ашиглана уу.
12. Бариул, хошуунаас нь эд зүйлсийг бүү барь.
13. Үзмэрийг барихын тулд хоёр гараа үргэлж ашигла. Тухайн үзмэрийн жин тэнцвэртэй байгаа эсэхийг нягтлан нэг гараа түүний доор байрлуулж, нөгөө гараараа тэврээрэй.
14. Цаасан дээрх урлагийн бүтээлүүд, баримт бичиг, муутуу гэх мэт эмзэг материалд суурилсан үзмэртэй ажиллахын тулд тэдгээрийг тээвэрлэх картон, хатуу хавтанг ашиглана. Тээвэрлэлтийн явцад шахалтаас зайлсхийхийн тулд өөр хатуу тулгуураар хучих хэрэгтэй.
15. Эмзэг зүйлсийг үргэлж тохиромжтой хэмжээтэй хайрцагт хийж, санамсаргүй цохилтоос зайлсхийхийн тулд зөөлөвч материалыг нэмж оруулаарай.
16. Хурц булан эсвэл ирмэгтэй үзмэртэй харьцахдаа болгоомжтой байгаарай, хэрэв боломжтой бол бусад үзмэрийг гэмтээхгүйн тулд тэдгээрийг даавуу, цаас эсвэл хөөсөөр боож өгнө.
17. Үзмэрийг тээвэрлэхээс өмнө сүл эсвэл салж болохуйц хэсгийг хамгаалж, бэхлэх хэрэгтэй. Ингэснээр та гэмтэх, хулгайд алдах эрсдэлийг багасгаж чадна.



10

Гэрэл зургийг СӨҮТ



Гэрэл зургийг СӨҮТ





1. Үзмэрүүд нь урт удаан хугацааны насжилт болон олон жилийн эдэлгээнээс хамааран буруу савлалтаас болж эвдэрч гэмтэх эрсдэлтэй байдаг. Ийм учраас үзмэрийг яаралтай нүүлгэн шилжүүлэхэд зориулж савлахдаа дараах зүйлийг анхаарах хэрэгтэй.


 - Ашигласан баглаа боодлын материал нь үзмэрийн гадаргууг хамгаалах ёстой бөгөөд үүний зэрэгцээ цочрол, чичиргээ, тоос шороо болон бусад бохирдуулагч бодис, гадна орчны огцом хэлбэлзлээс хамгаалах ёстой.
 - Хэт даралт өгөх, хэв гажилтаас зайлсхийхийн тулд савлагаанд ашигласан материал нь тухайн зүйлийн хэлбэр, хэмжээтэй тохирч байх ёстой.
 - Энэ нь үзмэрийг баглаа дотор нь тодорхойлоход хялбар байх ёстой. Мөн тэдгээрийн тээвэрлэлтийн зохицуулалтад тусална.
2. Сав баглаа боодлын материалыг зөв сонгохын тулд савлах шаардлагатай зүйлсийг үйлдвэрлэхэд ашигласан материалыг тодорхойлох нь чухал юм. Жишээлбэл, цаасан дээр суурилсан эд зүйл, эдлэлийг савлахдаа хүчил ялгаруулж болзошгүй саванд хийхгүй байх нь чухал юм (Жишээ нь, шинэ модоор хийсэн бүх зүйл, фанер гэх мэт).
3. Байгаа материалуудаасаа үзмэртэй шууд бус урвал бүхий сайн чанартайг сонго.
4. Цардуулгүй хөвөн эсвэл будаггүй марлийг ихэнх органик болон органик бус материалыг бооход ашиглаж болно. Савлах материал цуглуулахдаа өөр өөр зориулалтаар ашиглаж болох материалыг сонгохыг хичээ. Энэ нь зардлыг бууруулах, нөөцийг үр ашигтай ашиглахад тусална.
5. Үзмэрүүдийг савлахдаа таглаатай, бусад хайрцагны доор байрлуулахад хангалттай бат бөх хайрцгийг сонго.
6. Хэрэв та хуучин хайрцаг эсвэл сав хэрэглэж байгаа бол түүнд хүнсний ногоо, хортон шавьж, химийн бодисын үлдэгдэл зэрэг бохирдуулагч бодис байхгүй эсэхийг шалгаарай.



Гэрэл зургийг СӨҮТ



- 7.** Ижил төстэй материалаар хийсэн эд зүйлсийг хамтад нь хайрцагт хийнэ. Гэсэн хэдий ч үзмэрүүдийн хооронд харшилдахаас сэргийлэхийн тулд хуваалт эсвэл зөөлөвч материалыг ашигла.
- 8.** Хөнгөн болон хүнд зүйлийг тээвэрлэхдээ нэг хайрцагт хийж болохгүй, хүнд зүйл нь хөнгөн зүйл дээр унаж, даралт үүсгэдэг.
- 9.** Үзмэрийг хайрцагт байрлуулсны дараа, хөдөлгөөнд орохоос сэргийлж, чичиргээг багасгахын тулд хоосон зайг зөөлөвч материалаар дүүргэ.
- 10.** Үнэ цэнтэй баримт бичиг, уран зургийг муутуугаар ороож савлахдаа хавтгай хайрцаг ашиглана. Эсвэл хөвөн даавуугаар хийсэн цаас гэх мэт сайн чанарын цаасаар үзмэрийг боож, дараа нь хоёр хатуу тулгуурын хооронд байрлуул.
- 11.** Нэгээс олон цаасан зүйлийг савлахдаа сайн чанарын хоосон цаасаар тус тусад нь салга. Энэ нь нэг үзмэрээс нөгөө рүү бэх эсвэл өнгө шилжих эрсдэлийг бууруулна.
- 12.** Номын хэлбэр, бүтцийг хадгалахын тулд сайн чанарын цаасаар боож, дараа нь хайрцагт хийнэ.
- 13.** Цаас, даавуу эдлэл дээрх том хэмжээтэй болон хүрээгүй урлагийн бүтээлийг савлахын тулд архивын баримт хуйлдаг цаасны дотор хоолойг ашиглаж, зургийн нүүрэн тал дээгүүр өнхрүүлэх. Төгсгөлд нь ороомгийг марль эсвэл сайн чанарын гараар хийсэн цаасаар бүрнэ. Архивын баримтын цаасны дотор хоолой байхгүй тохиолдолд зузаан ханатай картон хоолой ашиглаж, дээр нь эд зүйлийг өнхрүүлэхээсээ өмнө марль эсвэл сайн чанарын цаасан дээр боож өгнө. Хоолойн голч нь том байгаа эсэхийг шалгаарай, учир нь энэ нь үрчлээс үүсэх эрсдэлийг бууруулахад тусална.
- 14.** Шавар шаазан гэх мэт материалаар хийсэн хэврэг зүйлийг савлах мөн шилэн эсвэл керамикийг нэг том саванд хийхээсээ өмнө тусад нь гялгар уутанд хийнэ. Бусад үзмэртэй харшилдахаас сэргийлж, үрэлтээс болж гэмтэхээс зайлсхийхийн тулд зөөлөвч болон хуваалтыг ашигла.



15. Яаралтай нөхцөлд зөв савлагааг хангахын тулд дамжлагын зарчмаар ажиллана, өөрөөр хэлбэл нэг хүн баглаж боож, нөгөө нь хайрцаг бэлтгэх, өөр хүн тухайн үзмэрт тусгай дугаар бүхий шошго зүүж бэхлэн, бэлтгэсэн саванд хийнэ.
16. Бүх хайрцагнууд нь тэдгээрт агуулагдсан үзмэрийн тоо, төрлийг харуулсан шошготой эсэхийг шалгаарай.
17. Үзмэрийг агуулсан хайрцагтай буруу харьцахаас зайлсхийхийн тулд тэдгээрийг хэврэг, дээд/доод, болгоомжтой, доош эргүүлж болохгүй гэсэн тэмдэглэгээг (доор үзүүлсэн шиг) тэмдэглэнэ.







Гэрэл зургийг СӨҮТ



5 ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ, ТЭЭВЭРЛЭХ



Үзмэрүүдийг савлахдаа тухайн зүйлийн таних дугаарыг агуулсан шошго бүрэн бүтэн байгаа эсэхийг шалгаарай. Сав баглаа боодлын түшлэг, бариул нь мөн шошготой байх ёстой.



Баримтжуулалтын нэгжийн дор хаяж нэг гишүүн дараах маягыг бөглөх замаар үзмэрүүдийг янз бүрийн хайрцагт баглах явцыг хянаж байгаа эсэхийг шалгаарай. Шилжилт хөдөлгөөн хянах маягыг олон хувь бэлтгэнэ үү.

Шилжилт хөдөлгөөн хянах маягт


| Нэвтрэх дугаар | Хайрцгийн дугаар | Хайрцагт байгаа зүйлийн тоо | Зөөвөрлөх тээвэрлэх заавар | Гүйцэтгэгч | Явсан өдөр |
|----------------|------------------|-----------------------------|----------------------------|---------------------|-------------------|
| 1 | 12 | 20 | Шил: анхаарал тавих | Чимгээ үзмэр харагч | 1 дүгээр сарын 25 |
| ... | ... | ... | ... | ... | ... |

Тэмдэглэл:

Шилжилт хянах маягтын сүүлийн 4 багана нь түр хадгалах агуулах хариуцсан ажилтанд хамааралтай.

6 ХЯНАЛТЫН ЖАГСААЛТ

Бүх үзмэрүүдийг савлаж дууссаны дараа тэдгээрийг шинэ аюулгүй газар руу тээвэрлэхэд бэлэн болно. Савлалт нь өмнөх алхамд тайлбарласны дагуу бүртгэлийн болон шилжилт хөдөлгөөний маягтын хуулбарыг агуулсан байх ёстой.




| Тээврийн хэрэгслийн дугаар | Хүлээн авсан өдөр | Хайрцгийн дугаар | Хайрцагт байгаа зүйлийн нийт тоо | Хүлээн авсан |
|----------------------------|-------------------|------------------|----------------------------------|-----------------|
| xxx 256 | 1 дүгээр сарын 25 | 12 | 20 | Агуулахын нярав |
| ... | ... | ... | ... | ... |



Нүүлгэн шилжүүлэх, хадгалах

- 1 ЗАЙ БЭЛДЭХ
- 2 ҮЗМЭРҮҮДИЙГ ЭРЭМБЭЛЭХ
- 3 ШИНЭ БАЙРШЛЫГ БҮРТГЭХ
- 4 ХАМГААЛАХ
- 5 ТАЙЛАГНАХ
- 6 ХЯНАХ






1 ЗАЙ БЭЛДЭХ

Багийн нэг хэсэг нь үзмэрийг баримтжуулах, савлах ажилд оролцож байхад нөгөө хэсэг нь шинэ талбайд хадгалах зайг бэлдэхэд анхаарлаа хандуулах ёстой. Үүнд шинэ байршлыг ариутгасан эсэхийг, мөн аюулгүй (18-р хуудсыг үзнэ үү) болон байршлын кодын систем байгаа эсэхийг шалгана.

Шинэ орон зайд үзмэрүүдийг хэрхэн сайн байрлуулах талаар энэ хэсэгт өгүүлнэ.

Ашиглах боломжтой тавилгуудыг зохих ёсоор байрлуулж, үзмэрийн шинэ байршлыг тэмдэглэхийн тулд шүүгээ болон тавиурын байршлын кодыг зааж өгнө үү. Үүнийг үзмэр шилжиж ирэхээс өмнө гүйцэтгэсэн эсэхийг шалгаарай.

Яаралтай нүүлгэн шилжүүлэх үед тавиур гэх мэт тохиромжтой тавилга худалдаж авах боломжгүй байж магадгүй бөгөөд энэ тохиолдолд эд зүйлсийг сав баглаа боодолтой нь шалан дээр хадгална. Үзмэрийг агуулсан хайрцаг болон шал хооронд шууд хүрэлцэхгүйн тулд тавиур эсвэл брезент (усанд тэсвэртэй материал) хэрэглээрэй. Хэрэв та модон тавиур ашиглаж байгаа бол тэдгээр нь хортон шавьжаар халдварлаагүй эсэхийг шалгаарай.




Зөвлөмж: Түр хадгалах зайд байршлын кодын системийг хэрхэн боловсруулах вэ?



Байршлын кодын тогтвортой системийг боловсруулах энгийн арга нь будаг, наалддаг тууз эсвэл олсоор шалан дээр шугам зурах юм. Шалны талбайг тохирох урттай квадратуудад хуваана.

Жишээ нь, 1 м х 1 м. Мөр, баганыг ялгахын тулд үсэг, тоо ашиглана. Эдгээрийг тэмдэглэхийн тулд ханан дээр шошго ашиглана.




Үзмэрүүдийг ангилж, тус тусын агуулахад байрлуулсны дараа нэгж, байршлын кодыг бүрэн бичих, жишээ нь. ШХС (Шинэ хадгалах сан), 0 (доод давхар), 1 (өрөөний дугаар), 3А (Үзмэр байршил), 128 (өгөгдсөн өвөрмөц дугаар), 20-р хуудсыг үзнэ үү.



2 ҮЗМЭРҮҮДИЙГ ЭРЭМБЭЛЭХ


Шинэ газарт үзмэрүүдийг албан ёсоор хүлээн авсны дараа (40-р хуудсыг үз) дагалдаж ирсэн яаралтай нүүлгэн шилжүүлэлтийн бүртгэлийг шалгаж, үзмэрүүдийг материалын төрөл, хэмжээгээр нь ялгана.

Үзмэрүүдийг ариутгасан тавиур болон бусад боломжтой тавилга дээр байрлуулна (сав, баглаа, боодолтойгоор нь). Эмзэг зүйлсийг газраас хол байлгаж, өрөөний буланд, хялбар хүрэхээргүй газар байрлуулахыг хичээгээрэй. Үүний нэгэн адил жижиг зүйлийг зөөх, зохион байгуулах зайг чөлөөлөхийн тулд том эсвэл хүнд зүйлсийг өрөөний нэг буланд төвлөрүүлж байрлуулах хэрэгтэй .



3 ШИНЭ БАЙРШЛЫГ БҮРТГЭХ

Шинэ түр агуулахад байгаа үзмэр бүрийн бодит байдлыг баримтжуулахын тулд түр агуулахын бүртгэлд хайрцагны дугаар, тавиурын дугаарыг тэмдэглэнэ үү.



4 ХАМГААЛАХ

Хулгай, эвдрэл гэмтлээс урьдчилан сэргийлэхийн тулд шинэ түр хадгалах газарт аюулгүй байдлын зохих арга хэмжээг авна уу. Шаардлагатай бол харуулуудыг байрлуулна.



⚠ Анхааруулга: Зэвсэг мөргөлдөөнтэй газруудад аюулгүй байдлын нөхцөл байдлыг байнга хянаж байх нь чухал бөгөөд хэрэв шаардлагатай бол үзмэрүүдийг дахин өөр байршилд шилжүүлэхэд хангалттай хугацаа байх болно.



5 ТАЙЛАГНАХ

Шинэчлэгдсэн бүртгэл, тооллого ба үзмэрүүдийн шинэ байршлын хамт мэдээллийг иж бүрнээр нь холбогдох байгууллагад хүргүүлэх.



6 ХЯНАХ

Үзмэрүүдийг гэмтээх хортон шавьж, гал түймэр, ус болон бусад төрлийн бодисоос зайлсхийхийн тулд шинэ түр агуулахыг цэвэрлэх, хянах горимыг боловсруулна.



Үзмэрүүдтэй харьцах болон савлах

- Bendix, C. 2013. Moving Collections. London, Preservation Advisory Centre, British Library. Available at: http://www.bl.uk/aboutus/stratpolprog/collectioncare/publications/booklets/moving_library_and_archive_collections.pdf [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/35Z6-HCPL>

- Heritage Collections Council. 1998. reCollections: caring for collections across Australia. Handling, Transportation, Storage and Display. Canberra, Heritage Collections Council. Available at: https://aiccm.org.au/sites/default/files/docs/reCollections/6_htsd.pdf [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/6HNW-HAKW>

- Museum of London. 2013. Assessing the Object: What is the object made from? Available at: <http://www.museumoflondon.org.uk/Resources/e-learning/packing-museum-objects-for-storage/s03p01.html> [Accessed 30 December 2015].
- Shelley, M. 1987. The Care and Handling of Art Objects: Practices in the Metropolitan Museum of Art. New York, The Metropolitan Museum of Art. Available at: http://www.metmuseum.org/research/metpublications/The_Care_and_Handling_of_Art_Objects_Practices_in_The_Metropolitan_Museum_of_Art [Accessed 16 December 2015].

Permanent link: <https://perma.cc/2DZP-L7QW>

- Stolow, N. 1981. Procedures and conservation standards for museum collections in transit and on exhibition. Protection of the Cultural Heritage: Technical Handbooks for Museums and Monuments 3. Paris, UNESCO. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0004/000468/046862eo.pdf> [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/MWK8-HZRE>

- UNESCO. 2006a. Care and Handling of Manuscripts. Cultural Heritage Protection Handbook No. 2. Paris, UNESCO. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0014/001484/148463E.pdf> [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/QPQ5-XPW5>

- UNESCO. 2006b. Handling of Collections in Storage. Cultural Heritage Protection Handbook No. 5. Paris, UNESCO. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0018/001879/187931E.pdf> [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/AD26-63WK>

Цуглуулгын тээвэрлэлт

- Stolow, N. 1981. Procedures and conservation standards for museum collections in transit and on exhibition. Protection of the 50 Annex
- 51 Cultural Heritage: Technical Handbooks for Museums and Monuments 3. Paris, UNESCO. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0004/000468/046862eo.pdf> [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/MWK8-HZRE>

Сан хөмрөгийн зохион байгуулалт

- Canadian Conservation Institute. 2002. General Precautions for Storage Areas. CCI Notes 1/1. Ottawa. Available at: http://cci-icc.gc.ca/resources-ressources/ccinotesicc/1-1_e.pdf [Accessed 9 December 2015].

Permanent link: <https://perma.cc/2JJ3-897G>

- Johnson, E.V. & Horgan, J.C. 1979. Museum collection storage. Protection of the Cultural Heritage: Technical Handbooks for Museums and Monuments 2. Paris, UNESCO. Available at: <http://unesdoc.unesco.org/images/0004/000423/042316eo.pdf> [Accessed 9 December 2015]. Permanent link: <https://perma.cc/R33E-CA8N>

Хавсралт

Цуглуулгыг яаралтай нүүлгэн шилжүүлэхэд ашиглаж болох материал, тоног төхөөрөмжүүд

ХАМГААЛАЛТЫН ХЭРЭГСЭЛ

- **Амны хаалт:** Тоос болон бусад агаарын тоосонцорыг амьсгалахаас сэргийлэхийн тулд нүүрний маск хэрэглээрэй. Химийн бодисоор бүрсэн үзмэртэй харьцахдаа шүүлтүүртэй маск хэрэглээрэй.
- **Бээлий:** Үзмэрүүдтэй харьцахад хөвөн, нитрил эсвэл латекс бээлий хэрэглэж болно. Гэхдээ латекс бээлий нь харшлын урвал үүсгэдэг гэдгийг санаарай.
- **Хамгаалалтын шил:** Хэрэв та тоостой эсвэл бохирдсон орчинд ажиллаж байгаа бол нүдээ хамгаалахын тулд хамгаалалтын шил хэрэглээрэй.
- **Хамгаалалтын дуулга:** Хатуу малгай гэж нэрлэгддэг хамгаалалтын малгай нь толгойг дээрээс унах үзмэрээс хамгаалахад ашиглагддаг.
- **Хормогч/Лабораторын цув:** Үзмэртэй харьцах, савлах үед хувцсаа бохирдуулахгүйн тулд маалинган даавуу, хөвөн эсвэл хөвөн полиэстерээр хийсэн хормогч, цагаан өнгийн лабораторын цув хэрэглээрэй.
- **Тодруулагчтай хантааз:** Хэрэв та харанхуй газар ажиллаж байгаа эсвэл хялбар ялгарч харагдахыг хүсч байвал яаралтай тусламжийн ажилтнуудын ашигладаг шиг алсаас харагдахуйц цацруулагч түүз эсвэл өнгө бүхий хүрэм хэрэглээрэй.
- **Анхны тусламжийн хайрцаг:** Нүүлгэн шилжүүлэх багт анхны тусламжийн иж бүрдэл заавал байна. Иж бүрдэлд ундны ус, гэрэл, нөөц батерейг багтаагаарай.

Тэмдэглэл: Зэвсэгт мөргөлдөөн болж байгаа газруудад сум нэвтэрдэггүй хантааз, хийн маск гэх мэт бусад хамгаалалтын хэрэгсэл шаардлагатай байж болно.

БАРИМТЖУУЛАЛТ

1. **Камер** (сэлбэх тэжээлтэй) гэрэл зургаар баримтжуулахад ашиглана.
2. **Зургийн дэвтэр, тэмдэглэлийн дэвтэр**
3. **Бал, харандаа**
4. **Наалддаг тууз** эсвэл шошго, савлагаа уях даавуун тууз
5. **Наалт бүхий шошгыг** савлагаан дээр үзмэрүүдийн таних дугаарыг бичихийн тулд ашиглана. Уг шошгыг үзмэрүүдийн гадаргуу дээр нааж болохгүй.

САВЛАГАА

Бид хялбар олдох материалыг жагсаасан. Гэвч онцгой нөхцөлд тодорхой материалыг их хэмжээгээр авах боломжгүй байх магадлалтай. Ийм нөхцөлд үзмэртэй шууд харьцах хамгийн сайн материалыг ашигла. Жишээлбэл, хөвөн эсвэл марль ашиглан үзмэрийг ороож, дараа нь цаасан хайрцагт хийнэ.

- **Марль [1]:** Өргөн тархсан байдгаар нь цардуулгүй, цагаан марль эсвэл нарийн хөвөнг ихэнх үзмэрийг аюулгүй болгох үүднээс зөөлөвч материал болгон ашиглаж болно.
- **Шүлтгүй цаас [2]:** Энэ нь хүчил агуулаагүй, амархан олдоцтой, хөвөн эсвэл маалинган даавуугаар хийсэн цаасыг болон нэхмэл эдлэл дээрх уран зураг бооход ашиглаж болно.
- **Полиэфир хальс, плёнка:** Энэ нь гэрэл зураг эсвэл бусад цаасан баримтыг хадгалахад ашигладаг ил тод, өнгөгүй хуванцар хуудас юм. Энэ нь ихэвчлэн Mylar эсвэл Melinex гэж зарагддаг.
- **Тайвек:** Өндөр нягтралтай полистер утсаар хийсэн синтетик материал болох тайвек нь усанд тэсвэртэй бүрээс хийхэд ашиглагдана. Барилга угсралтын явцад барилга байгууламжийг хамгаалахад ихэвчлэн ашигладаг.
- **Тарпаулин**
- **Полиэтилен хөөс [3]:** Эда хөөс гэдгээрээ ихэвчлэн зарагддаг, полиэтилен хөөсийг зөөлөвч материал болгон ашиглаж болно, учир нь энэ нь үзмэрийг баглаа боодолдоо багтаасны дараа чичиргээг шингээхийн тулд амархан хэлбэрт оруулж болдог.



- **Бөмбөлөгтэй боодол [4]:** Богино хугацааны шийдэл болох хөөсөн боодлыг чигжээс материал болгон ашиглаж болно. Гэсэн хэдий ч хөөсөн гадаргуу нь үзмэртэй шууд хүрэлцэж болохгүй.
- **Дэр:** Энгийн дэр нь хэврэг зүйлийг савлахад ашиглаж болно.
- **Алчуур:** Цагаан даавуун алчуур нь үзмэрийг зөөлөвч материал болгон ашиглаж болно.
- **Пластик уут:** Хүнсний полиэтилен уутыг эмзэг эсвэл жижиг зүйлийг савлахад ашиглаж болно.
- **Картонон хайрцаг [5]:** Энгийн картон хайрцгийг үзмэрийн сав болгон ашиглаж болно. Гэсэн хэдий ч урт хугацааны турш хүчиллэг уур ялгаруулж, үзмэрүүдэд хортой нөлөө үзүүлдэг. Үзмэрүүдийг хамгаалахын тулд хайрцагны дотор талыг цардуулгүй, будаггүй хөвөн эсвэл хүчилгүй цаасаар доторлохыг зөвлөж байна.
- **Модон жимсний хайрцаг:** Ийм хайрцаг нь ихэвчлэн чанар муутай байдаг. Мод, чулуу, шавар зэрэг органик материалыг тээвэрлэхэд ашиглаж болно. Гэсэн хэдий ч энэ хайрцаг нь цаас эсвэл хөвөн доторлогоотой байх ёстой. Ийм хайрцгийг ашиглах нь богино хугацааны шийдэл юм.
- **Хуванцар хайрцаг [6]:** Хуванцар материалаар хийсэн тунгалаг сав, ихэвчлэн хоол хүнс хадгалах зориулалттай байдаг. Хэврэг эсвэл жижиг зүйлийг хадгалах сав болж чаддаг.
- **Хуванцар сагс:** Ихэвчлэн сүүний хайрцаг, жимс жимсгэнэ, хүнсний ногоо зөөвөрлөхөд ашигладаг, тус хуванцар хайрцаг нь эд зүйлсийг хадгалах, тээвэрлэх богино хугацааны өөр нэг шийдэл юм.
- **Хуванцар тавиур:** Музей, архивт ихэвчлэн ашигладаг, хуванцараар хийсэн тавиурыг эд зүйлсийг аюулгүй хадгалах, тээвэрлэхэд ашиглаж болно.
- **Ороох хоолой:** Өргөн диаметртай, дугуй голчтой хоолойг цаас, нэхмэл эдлэл дээрх зотон болон урлагийн бүтээлүүдийг савлахад ашиглаж болно.



4



5



- **Тавиур [7]:** Хуванцар эсвэл модон тавиурыг үзмэр агуулсан хайрцгийг хадгалах, газраас хөндий байлгахад ашиглаж болно. Гэсэн хэдий ч модон тавиурыг ашиглахдаа үзмэр агуулсан хайрцагтай шууд хүрэлцэхгүй, тэдгээр нь шавжаар халдварлаагүй байх ба хуванцар тусгаарлагч эсвэл тайвекээр бүрсэн эсэхийг шалгаарай.



БУСАД ХЭРЭГЛЭЛ:

- Хайч
- Олс
- Шугам
- Туузан метр
- Хувин
- Шат
- Тэрэг (түрдэг тэрэг гэх мэт)
- Тулах зүйл
- Том дугуйтай тэрэг





Франц улс, Парис хот, Фонтеной
75352
www.unesco.org
Холбоо барих: +33 (0)1 45681000



Итали улс, Ром хот, Сан Мишель 13
www.iccrom.org
Холбоо барих: +39-06585531
Факс: +39-0658553349



Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул
дүүрэг, 21-р хороо, Буянт-Ухаа 2
www.ncch.gov.mn
Холбоо барих: 7777-9003
7777-9004

